

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ
АРГА ХЭМЖЭЭНИЙ 72 ХУВИЙГ ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД БОДИТ НЭМЭР
БОЛОХУЙЦ ҮР НӨЛӨӨ БҮХИЙ АЖИЛД ЗАРЦУУЛСАН БАЙНА.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ГСА-2024/26-ШТА-ГА

Говьсүмбэр аймаг

2024

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа, Утас: 70543156
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр, Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179 Цахим
хаяг: Darkhanbatb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Анхтуяа, Утас: 70543179 Цахим
хаяг: Ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер
Г.Наранбаяр

Ахлах аудитор
Б.Дарханбат

Б.Анхтуяа

Аудитор

С.Батцэцэг

Г.Ариунцэцэг

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70543156, 70543179
дугаарын утсаар харилцана
уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 205 тоот

2024 оны 7 дугаар сар

ТОВЧИЛСОН ҮГС 3

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, сумдад хуваарилсан байна. 7

1.1 Улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалан аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилт 1.5 хувиар дутуу олгогдсон байна. 7

1.2 Иргэдийн зүгээс ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний санал асуулгад идэвхтэй оролцсон боловч тэдний гаргасан саналыг журмын дагуу эрэмбэлж ИТХ-аар батлуулаагүй..... 9

2. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний 72 хувь нь орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр болохуйц үр нөлөөтэй хэрэгжсэн байна. 14

2.1. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байна. 14

2.2. Иргэдийн амьдралын орчин нөхцөлийг сайжруулах, орон нутгийн хөгжилд бодит нэмэр болохуйц хөрөнгө оруулалт, арга хэмжээ 72 хувийг эзэлж байна. 17

2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон нийт хөрөнгийн 5.5 хувийг зориулалтын дагуу огт ашиглаагүй, 3 хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зохисгүй байна. 20

3. ОНХС-гийн үйл ажиллагаанд тавих хяналтыг иж бүрэн хэрэгжүүлээгүй, Удирдлага мэдээллийн системээр дамжуулан иргэд олон нийтэд ил тод тайлагнаагүй байна. 22

3.1 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээний зөвхөн гүйцэтгэлийн үе шатанд хяналт хэрэгжсэн байна. 22

3.2. ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний мэдээллийг Шилэн дансны цахим хуудас болон Удирдлага мэдээллийн системд ил тод тайлагнаагүй байна. 25

Дүгнэлт

Зөвлөмж

Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлан баталгаажуулах тушаал

Тайлангийн хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АМ	Ашигт малтмал
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АОНХС	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НАТ	Нөөц ашигласны төлбөр
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХАА	Санхүүгийн хяналт аудитын алба
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТА	Тогтвортой амьжиргаа
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТББ	Тендерийн баримт бичиг
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УМС	Удирдлагын мэдээллийн систем
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХО	Хөрөнгө оруулалт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл,
бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/152, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162, “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны А/100 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”;
- Засгийн газрын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”;
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд

Аудитын хамарсан
хүрээ:

Аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, ХОХБТХ, СТСХ, СХДАА, ГХБХБГ, Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн газар, Багийн ИНХ, Засаг дарга, аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, Б.Анхтуяа, аудитор С.Батцэцэг, Г.Ариунцэцэг нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын нээлтийг 2024 оны 05 дугаар сарын 22-нд хийж, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс 6 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 07 дугаар сарын 01-ний дотор боловсруулан, тайланг дарга, Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага албан тушаалтанд 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр хүргүүлээ.

Хүндрэл бэрхшээл:

Тус аудитыг сүүлийн хагас жилд гүйцэтгэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан боловч аудитын төлөвлөгөөний хугацаа өөрчлөгдсөн, “Орон нутгийн төсвийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, орлогын бүрдүүлэлт, зарцуулалт” гүйцэтгэлийн 2, “Орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох” нийцлийн 1, нийт 3 аудит зэрэг давхацсан, орон тооны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан /ахлах аудитор 2, аудитор 2/аудитыг гүйцэтгэхэд хүндрэл бэрхшээл үүсэж байна. Мөн Төрийн аудитын байгууллагын эхний хагас жилийн тайлан, мэдээний хугацаатай давхацсан нь ажлын ачааллыг нэмэгдүүлсэн, цаг хугацааны хязгаарлагдмал байдал үүсгэсэн.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Говьсүмбэр аймагт Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 5,731.5 сая, малын тоо толгойн албан татварын орлого 148.8 сая, өмнөх оны үлдэгдлээс санхүүжих 705.6 сая, бусад эх үүсвэрээс 173.3 сая, нийт 6,759.2 сая төгрөгийн орлогыг төлөвлөсөн байна.

Үүнээс гүйцэтгэлээр 6,610.7 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлжээ.

Аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор 6,759.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 107 хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд шинээр хэрэгжих 6,424.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 98 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 4,960.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 82 ТАХ-нд 4,585.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Худалдан авах ажиллагаа зарласан боловч шаардлага хангасан гүйцэтгэгч шалгараагүй 1,229.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8, худалдан авах ажиллагаа зарлаагүй 100.0 сая төгрөгийн 1, босго үнийн хязгаарт багтсан шууд гэрээ байгуулах боломжтой 134.5 сая төгрөгийн 7, нийт 1,463.8 сая төгрөгийн 16 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний худалдан авалт амжилтгүй болсон байна.

Дүрслэл товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ОНХС-ийн эх үүсвэр	6
Дүрслэл 2	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний эрэмбэлсэн жагсаалтад ороогүй ажлууд	9-10
Дүрслэл 3	Аймаг сумдын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцээгүй төсөл арга хэмжээ	11
Дүрслэл 4	2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг журмын 4.2-т заасан чиг үүргийн ангилал	12
Дүрслэл 5		

Хүснэгтийн товьёг


№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн ОНХС-ийн орлогын шилжүүлгийн тооцоолол	6
Хүснэгт 2	Сумдын ОНХС-ийн орлогын шилжүүлгийн тооцоолол	7
Хүснэгт 3	Сумдын ОНХС-ийн санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл	7
Хүснэгт 4	Нэмсэн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл	8
Хүснэгт 5	Санал авах өрхийн тоог санал авсан өрхийн тооны харьцаа	8
Хүснэгт 6	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалт	9
Хүснэгт 7	Аймаг, сумдын хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлд нийцсэн эсэх судалгаа	10-11
Хүснэгт 8	Тайлант хугацаанд гэрээ байгуулсан ТАХ-ний худалдан авах ажиллагааны судалгаа	13-14
Хүснэгт 9	Баримтын бүрдэл дутуу ажлын жагсаалт	14
Хүснэгт 10	Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ ангилал салбараар	19
Хүснэгт 11	Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ХО-ын ажлын судалгаа	23
Хүснэгт 12	УМС-д мэдээлээгүй зөрчлийн судалгаа	25

Зураг товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийсэн усалгааны худаг	20
Зураг 2	Ус нөөцлөх сав 2ш, усалгааны систем	20
Зураг 3	Дээжийн хөлдөөгч	21

БҮЛЭГ 1**1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, сумдад хуваарилсан байна.****1.1 Улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалан аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилт 1.5 хувиар дутуу олгогдсон байна.****1.1.1 ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн байна.**

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар ОНХС-аас Говьсүмбэр аймагт олгох орлогын шилжүүлгийг 4,632.4 сая, төсвийн тодотголоор нэмэгдүүлж 5,731.5 сая төгрөгөөр тус тус баталсан байна. ОНХС эх үүсвэр тус бүрээр задалж харуулбал,

Дүрслэл №01 ОНХС-ийн эх үүсвэр*Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн аймгийн ОНХС-ийн эх үүсвэр***1.1.2 Улсын төсвийн орлого бүрдүүлэлтээс шалтгаалан аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 1.2 хувиар дутуу санхүүжсэн байна.**

Сангийн яамнаас аймгийн ОНХС-ийн төсвийн төслийг авч хянадаггүй бөгөөд ОНХС-ийн эх үүсвэрийг өмнөх жилийн хэмжээнд тооцон төлөвлөсөн байна.

Хүснэгт №01 Аймгийн ОНХС-ийн орлогын шилжүүлгийн тооцоолол /сая төгрөгөөр/

Сумдын нэрс	ОУ-ын ТАТ-ийн урамшуулал	АМХТЗ төлбөр /сумдад хуваарилах суурь 50 хувь/	АМАТЗ төлбөр /сумдад хуваарилах суурь 50 хувь/	ОНХС орлогын шилжүүлэг /итгэлцүүр/	Нийт дүн
Аймаг	0.0	6.2	70.7	2,571.0	2,647.9
Аймгийн дүн	0.0	6.2	70.7	2,571.0	2,647.9

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн орлогын шилжүүлгийн суурь тооцоолол

ОНХС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг итгэлцүүрээр хуваарилагдах дүнгийн 50 хувиар буюу 2,571.0 сая төгрөгөөр тооцсон байна. АМХТЗ-ийн төлбөрөөс 6.2 сая, АМАТЗ-ийн төлбөрөөс 70.7 сая төгрөг хуваарилагдсан байна.

Улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалан 32.6 сая төгрөг буюу 1.2 хувиар дутуу санхүүжсэн байна.

1.1.3 Улсын төсвийн орлого бүрдүүлэлтээс шалтгаалан сумдын ОНХС-ийн санхүүжилт 1.8 хувиар дутуу олгогдсон байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2¹, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн

¹ Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна:

хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-д заасны дагуу Сангийн яамнаас сумдад хуваарилах орлогын шилжүүлгийн суурь тооцооллыг бэлтгэн ирүүлдэг бөгөөд аймгийн СТСХ-ээс сумдад дараах байдлаар хуваарилсан байна.

Хүснэгт №02 Сумдын ОНХС-ийн орлогын шилжүүлгийн тооцоолол /сая төгрөгөөр/

Сумдын нэрс	ОУ-ын ТАТ-ийн урамшуулал	АМХТЗ төлбөр /сумдад хуваарилах суурь 50 хувь/	АМАТЗ төлбөр /сумдад хуваарилах суурь 50 хувь/	ОНХС орлогын шилжүүлэг /итгэлцүүр/	Нийт дүн
Сүмбэр	216.2	-	10.5	1,269.5	1,496.2
Шивээговь	158.8	-	59.6	967.8	1,186.3
Баянтал	60.7	6.2	0.6	333.6	401.1
Сумдын дүн	435.7	6.2	70.7	2,570.9	3,083.6

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн орлогын шилжүүлгийн суурь тооцоолол

Сумдад ОНХС-ийн орлогын шилжүүлгийн санхүүжилт /итгэлцүүр/-ээс 2,570.9 сая, тогтвортой амьжиргаа төслийн урамшууллаас 435.7 сая, АМХТЗ-ийн төлбөрөөс 6.2 сая, АМАТЗ-ийн төлбөрөөс 70.7 сая төгрөг нийт 3,083.6 сая төгрөгийг хуваарилсан байна. Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг тооцоходоо орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ зэрэг шалгуур үзүүлэлтийг үндэслэн тооцсон байна.

Хүснэгт №03 Сумдын ОНХС-ийн санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Зардлын төрөл	Мөнгөн дүн /сая төгрөгөөр /			Нийт дүн
	Сүмбэр сум	Шивээговь сум	Баянтал сум	
Төлөвлөгөө	1,496.2	1,186.3	401.1	3,083.6
Гүйцэтгэл	1,469.2	1,163.3	395.4	3,027.9
Зөрүү	27.0	23.0	5.7	55.7

Эх сурвалж: ОНХС-ийн санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэлд хийсэн аудиторын тулгалт

Улсын төсвийн орлого бүрдүүлэлтээс шалтгаалан ОНХС-ийн орлогын шилжүүлэг 55.7 сая төгрөгөөр дутуу санхүүжсэн ба нийт санхүүжилтийн 1.8 хувийг эзэлж байна.

1.1.4 Аймгийн ОНХС-д нийт 322.2 сая төгрөгийн эх үүсвэр нэмж төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т ОНХС нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ гэж заасан байна. Үүнд:

ОНХС-аас олгох шилжүүлэг

Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр

Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг

АМХТЗ-ийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, 2020 төсвийн жилээс эхлэн АМАТЗ-ийн төлбөрийн орлогын 50 хувь

Малын тоо толгойн албан татварын орлого

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж

Энэ хуулийн 59.8-д заасан хуваарилалт

Аймгийн хэмжээнд 2023 онд нийт 322.2 сая төгрөгийн 3 эх үүсвэрийг нэмж төлөвлөсөн байна. Үүнд:

- Малын тоо толгойн албан татварын орлого 148.8 сая
- Шивээговь сумын ОНХС-д 2022 оны давсан орлогоос санхүүжих 13.4 сая
- Аймгийн ОНХС-д орон нутгийн давсан орлогоос санхүүжих 160.0 сая

Хүснэгт №04 Нэмсэн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Сумдын нэрс	Нэмж төлөвлөсөн орлого		Зөрүү	Нэмж төлөвлөсөн орлого		Зөрүү
	Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл			Давсан орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл		
Аймаг	0.0	0.0	0.0	160.0	160.0	0.0
Сүмбэр сум	84.8	67.2	17.7			
Шивээговь сум	45.0	13.5	31.5	13.4	12.9	0.5
Баянтал сум	19.0	8.4	10.6			
Нийт дүн	148.8	89.1	59.7	173.3	172.9	0.5

Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 40.1 хувь, давсан орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 99.8 хувьтай байна.

1.2 Иргэдийн зүгээс ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний санал асуулгад идэвхтэй оролцсон боловч тэдний гаргасан саналыг журмын дагуу эрэмбэлж ИТХ-аар батлуулаагүй байна.

1.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг иргэдээс хүртээмжтэй байдлаар авч эрэмбэлсэн байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх зохицуулалттай бөгөөд МУЗЗНДНТГТХ-ийн 32.6-д заасны дагуу тооцож үзэхэд 1244 иргэн иргэдийн нийтийн хуралд оролцсон байх шаардлагатай байна. Багийн ИНХ-д 1,936 иргэн оролцож ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-нд санал өгчээ.

Багийн иргэдийн нийтийн хуралд оролцож санал өгсөн иргэдийн тоо

Хүснэгт №05

Сумын нэр	Санал өгсөн байвал зохих	Санал өгсөн иргэдийн тоо	Зөрүү
Сүмбэр	865	919	(54)
Баянтал	120	185	(65)
Шивээговь	259	832	(573)
Нийт дүн	1244	1,936	(692)

(Эх сурвалж: Багийн ИНХ-ийн тэмдэглэл, тогтоол)

Аймгийн хэмжээнд 10 багийн 1936 иргэнээс ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх 203 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний саналыг гаргасан байна. Үүнээс сумын Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг дараах байдлаар эрэмбэлжээ.

Ажлын хэсгийн эрэмбэлсэн саналыг сумдаар задалж харуулбал:

Сүмбэр сумын санал 919 иргэн	Шивээговь сумын санал 832 иргэн	Баянтал сумын санал 185 иргэн
- Давхардсан тоогоор 72 төсөл арга хэмжээний санал - Ажлын хэсгээс эрэмбэлсэн: 27 төсөл арга хэмжээ - Аймгийн ОНХС-гаар хэрэгжүүлэх 8 ТАХ-ний санал - Сумын ОНХС-гаар 19 ТАХ-ний санал	- Давхардсан тоогоор 97 төсөл арга хэмжээний санал - Ажлын хэсгээс эрэмбэлсэн 31 төсөл арга хэмжээ - Аймгийн ОНХС-гаар хэрэгжүүлэх 6 ТАХ-ний санал - Сумын ИТХ-аар 11 төсөл арга хэмжээний санал	- Давхардсан тоогоор 34 төсөл арга хэмжээний санал - Ажлын хэсгээс эрэмбэлсэн 19 төсөл арга хэмжээ - Аймгийн ОНХС-гаар хэрэгжүүлэх 5 ТАХ-ний санал - Сумын ИТХ-аар 14 төсөл арга хэмжээний санал

(Эх сурвалж: 2022 оны багийн ИНХ-ын тэмдэглэл, ажлын хэсгийн эрэмбэлсэн баримт)

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний саналыг хуульд нийцүүлэн багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд 2023 онд 6,759.3 сая төгрөгийн 107 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр ИТХ-аар баталсан байна.

Хүснэгт №06 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалт

№	Нэр	ИТХ-ын тогтоолын огноо, дугаар	Төсөл арга хэмжээний тоо	Төсөв /сая төг/
1	Аймгийн ОНХС	2023.08.04 №03	37	3,098.5
2	Сүмбэр сумын ОНХС	2023.08.04 №03	28	1,833.2
3	Шивээговь сумын ОНХС	2023.09.04 №06	16	1,309.7
4	Баянтал сумын ОНХС	2023.08.23 №06	26	517.9
Нийт дүн			107	6,759.3

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6², Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 6 дугаар зүйлийн 6.4³, 7 дугаар зүйлийн 7.4⁴-д заасныг тулган баталгаажуулахад аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор иргэдийн санал аваагүй 2,652.2 сая төгрөгийн 22 төсөл арга хэмжээг баталсан байна. Энэ нь нийт ИТХ-аар баталсан төсөл, арга хэмжээний 20.6 хувийг эзэлж байна.

Дүрслэл №02 Иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй ТАХ-ний жагсаалт: /сая төгрөг/

**Аймаг
/13/**

1. Сүмбэр сумын 1-р баг тээвэрчдийн өргөн чөлөөний гудамж талбайн гэрэлтүүлэг 126.1 сая
2. Нарангийн гэр хороололд цахилгаан татах ажил 549.5 сая
3. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд усалгааны худаг гаргах, хашаа барих ажил 112.0 сая
4. Аймгийн төвд явган хүний замыг нэмэгдүүлэх ажил 70.0 сая
5. Агаарын чанарын мэдээлэл авах цэгийн цахилгаан хангамжийн ажил 12.1 сая
6. Баянтал суманд шинээр баригдсан "Ус түгээх худагт" ухаалаг тоног төхөөрөмж суурилуулах ажил-12.0
7. Сүмбэр суманд нийтийн эзэмшлийн талбай, тохижилтийн ажилууд хийхил 232.3 сая
8. Сүмбэр сумын 1-р баг Тээвэрчдийн өөгөн чөлөөнөөс 2 дугаар сургуулийн уулзвар хүртэлх авто замын ажил 40.0 сая
9. Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлгийн засвар шинэчлэлтийн ажил 150.0 сая
10. Төрийн байгууллагуудад шаардлагатай техник тоног төхөөрөмж худалдан авах 190.0 сая
11. Гамшгаас хамгаалах газар хөдлөлтийн чичирхийллийг хэмжих багаж суурилуулах худалдан авах 20.0
12. Гамшгаас хамгаалах аврах ажиллагааны хийлдэг завь худалдан авах 10.0 сая
13. Аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгт утаагүй хог шатаах зуух худалдан авах 500.0сая

**Сүмбэр
сум
/8/**

1. Өлзийт суурьшлийн бүсийн цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх, сайжруулах 230.0 сая
2. Усан сан, өргөх станцын эх үүсвэрийн автоматжуулалт 80.0 сая
3. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн усалгааны систем суурилуулах 100.0 сая
4. Сүмбэр сумын 1,2 дугаар багийн цэвэр усны шугам угаах 20.0
5. ЕБС-иудад сурагч ширээ, сандал худалдан авах / Мэдээлэл зүйн кабинет / 20.0 сая
6. Авто замын босоо тэмдэг, тэмдэглэгээг нэмэгдүүлэх 10.0 сая
7. Төрийн албан хаагчдад зориулсан нийтийн байрны засвар 116.8 сая
8. 6-р цэцэрлэгийн гал тогооны төхөөрөмж худалдан авах 21.4 сая

**Баянтал
сум**

- Шинээр худаг гаргах-30.0 сая

² орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ

³ Ажлын хэсэг нь баг, хороодоос ирсэн саналыг нэгтгэж эрэмбэлэхдээ дараах үзүүлэлтүүдийг харгалзан зөвлөмж, дүгнэлт гарган сум, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ:

⁴ Аймаг, нийслэлийн Засаг дарга ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан танилцуулна

Иргэдийн санал эрэмбэлээгүй ТАХ-г төлөвлөж өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.2.2 ОНХС-аар санхүүжүүлэхээр төлөвлөсөн нийт төсөл, арга хэмжээний 10 хувь нь орон нутгийн хөгжлийн бодлого, чиглэлтэй уялдаагүй байна.

Аймгийн Засаг даргын “2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон сумдын “2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдаагүй 11 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн байна.

Хүснэгт №07

Батлагдсан төсөл, арга хэмжээний тоо	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр		Сумдын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	
	Уялдсан	Уялдаагүй	Уялдсан	Уялдаагүй
107	35	2	61	9

Эх сурвалж: Аймаг, сумдын “2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”

2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаагүй төсөл, арга хэмжээг аймаг, сумдаар дүрслэлээр харуулав.

Дүрслэл №03

Аймгийн Засаг даргын
“2021-2024 оны үйл
ажиллагааны
хөтөлбөр”

- Төрийн байгууллагуудад шаардлагатай техник тоног төхөөрөмж 190.0 сая төгрөг
- Шивээговь сумын ариутгах татуургын шугамын ажлын төсвийг шинэчлүүлэх ажил-1.5 сая төгрөг
- Төсвийн байгууллагуудын засварын ажлын зураг төсөв боловсруулах ажил-10.0 сая төгрөг

Сүмбэр сумын
“2021-2024 оны үйл
ажиллагааны
хөтөлбөр”

- Сүмбэр сумын ЗДТГ-ын барилгын их засварын ажил-25.0 сая төгрөг
- 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөв /ТЭЗҮ/ боловсруулах ажил -20.0 сая төгрөг
- Иргэний танхим, төрийн үйлчилгээг сайжруулахад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах-75.0 сая төгрөг
- Төрийн албан хаагчдад зориулсан нийтийн байрны засвар-116.9 сая төгрөг

Шивээговь сумын
“2021-2024 оны үйл
ажиллагааны
хөтөлбөр”

- Шинэ суурьшлын бүсэд худаг гаргах-47.0 сая төгрөг
- Илчлэг шивээ ОНӨААТҮГ-т нүүрс тээврийн авто машин худалдан авах-240.0 сая төгрөг
- Төрийн албан хаагчдын орчин нөхцлийг сайжруулах арга хэмжээ
- 2024 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын их засварын ажлуудын зураг, төсөв-40.0 сая төгрөг

Баянтал сумын
“2021-2024 оны үйл
ажиллагааны
хөтөлбөр”

- Цэцэрлэгийн бүлэгт тоглоом нэмж авах-17.0 сая төгрөг

Эх сурвалж: Аймаг, сумдын “2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”

Орон нутгийн хөгжлийн бодлого, чиглэлтэй уялдаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 63.3⁵, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.1⁶, 6 дугаар зүйлийн 6.4.2⁷-д заасныг тус тус зөрчсөн байна.

⁵Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

⁶ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

⁷Сум, дүүргийн хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдсан эсэх;

Иймд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг аймаг, сумын хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусгах, аймаг, сумын ИТХ-аар батлуулах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.2.3 Төсвийн тухай хуульд заасан шаардлага, шалгуур хангаагүй 1,598.0 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажил Төсвийн тухай хуульд заасан шаардлага, шалгууртай нийцэж байгаа эсэхийг тулган баталгаажуулахад 1,779.7 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн байна. Үүнд: /дэлгэрэнгүйг Хавсралт №1-д харуулав/

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 1,155.6 сая төгрөгийн 11 ТАХ-г олон нийтээр хэлэлцүүлээгүй.
- Сүмбэр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 425.4 сая төгрөгийн ТАХ-нээс зураг төсөвгүй 2, олон нийтээр хэлэлцүүлээгүй 4 нийт 6 ТАХ байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29¹.1⁸, 29¹.2.6⁹-д Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2¹⁰-д заасныг тус тус зөрчсөн байна.

1.2.4 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт нийцээгүй 464.2 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2¹¹-т заасан чиг үүрэгт хамаарах ТАХ-г ОНХС-аас төлөвлөж, хэрэгжүүлсэн байх шаардлагыг тусгасан байна.

⁸ 29¹.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна

⁹ 29¹.2.6.олон нийтээр хэлэлцүүлсэн байх.

¹⁰ Аймаг, нийслэл нь сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хүлээн авч ОНХС-ийн ажлын хэсгээр хянаж эрэмбэлүүлнэ

¹¹ 4.2. Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

Category	Percentage
Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах	42%
Эд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ	27%
Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, Инновац, шинжлэн ухаан, цахим технологи	11%
Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулах	6%
Журамд заасан чиг үүрэгт хамааралгүй	5%
Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх	4%
Ажлын байр бий болгох	2%
Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулах	3%
Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах	1%

Нийт хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 42 хувийг орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах, 11 хувийг иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэн ухаан, цахим технологи, 27 хувийг дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ, 15 хувийг бусад чиг үүрэгт, 5 хувийг журамд заасан чиг үүрэгт хамааралгүй төсөл, арга хэмжээнд төлөвлөсөн байна.

1. Аймгийн ОНХС-гийн 190.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төрийн байгууллагуудад шаардлагатай техник тоног төхөөрөмж худалдан авах”
2. Сүмбэр сумын ОНХС-гийн 350.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2023 онд 25.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй “Сүмбэр сумын ЗДТГ-ын барилгын их засварын ажил”, 75.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Иргэний танхим, төрийн үйлчилгээг сайжруулахад шаардлагатай тоног төхөөрөмж”, 115.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төрийн албан хаагчдад зориулсан нийтийн байрны засвар”
3. Шивээговь сумын ОНХС-гийн 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төрийн албан хаагчдын орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээ”

Аймгийн ОНХС:

- Сүмбэр ОНХС:

- “Сүмбэр сумын ЗДТГ-ын барилгын их засварын ажил” 24.9 сая

- “Иргэний танхим, төрийн үйлчилгээг сайжруулахад шаардлагатай тоног төхөөрөмж” 74.8 сая
- “Төрийн албан хаагчдад зориулсан нийтийн байрны засвар” 81.7 сая
- Хөтөлбөр, арга хэмжээнээс шатахуун, хоол цай, шагнал дэмжлэг, бусад нийтийн эрх ашигт нийцээгүй 19.0 сая

Шивээговь сумын ОНХС:

- “Төрийн албан хаагчдын орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээ” 17.3 сая

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4¹², 60.3.6¹³-д Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.7.3¹⁴-д, 4.7.5¹⁵, 4.7.6¹⁶ заасныг тус тус зөрчсөн байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул Төсвийн тухай хууль болон журамд заасан шаардлага, шалгуур хангасан, чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг санхүүжүүлэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

БҮЛЭГ 2

2. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний 72 хувь нь орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр болохуйц үр нөлөөтэй хэрэгжсэн байна.

2.1. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байна.

2.1.1. Тендерийн баримт бичигт заасан шалгуур хангаагүй 3 оролцогчийг шалгаруулж гэрээ байгуулсан байна.

Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 2023 онд ОНХС-гаар 6,759.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 107 ТАХ-г баталсан үүнээс 335.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ажил 2022 оноос дамжин хэрэгжсэн.

Тайлант онд шинээр хэрэгжих 6,424.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 98 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд 4,960.4 сая төгрөгийн 82 ТАХ-нд 4,585.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Тайлант хугацаанд гэрээ байгуулсан ТАХ-ний худалдан авах ажиллагааг сонгон шалгаруулалтын төрлөөр нь дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 08

/сая төгрөгөөр/

№	ОНХС	Гэрээ байгуулсан ТАХ: Үүнээс		НТШ		ХА		ШХА		ЗҮ	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймаг	29	2,017.8	7	1,326.3	2	130.1	18	415.6	2	145.7
2	Сүмбэр	21	1,168.0	4	556.5	6	307.4	11	304.1		
3	Шивээговь	11	936.3	3	720.2	2	139.4	6	76.8		
4	Баянтал	21	463.6	1	95.6	3	139.7	17	228.3		
Нийт дүн		82	4,585.7	15	2,698.6	13	716.5	52	1,024.9	2	145.7

(Эх сурвалж: Аудитын судалгаа, ХАА-ны тайлан)

Худалдан авах ажиллагаа зарласан боловч шаардлага хангасан гүйцэтгэгч шалгараагүй 1,229.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8, худалдан авах ажиллагаа зарлаагүй 100.0 сая төгрөгийн 1, босго үнийн хязгаарт багтсан шууд гэрээ байгуулах боломжтой 134.5 сая төгрөгийн 7, нийт

¹² нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;

¹³ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

¹⁴ Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;

¹⁵ Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ;

¹⁶ Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал.

1,463.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон байна.

ОНХС-гийн тендер шалгаруулалттай холбоотой баримт материалыг шалгахад шаардлага хангахгүй оролцогчийг шалгаруулсан 3 тендер байна. Үүнд:

Аймгийн ОНХС:

“Баянтал сумын 154-р байрны техникийн давхрын төв инженерийн шугам сүлжээг засварлах шинэчлэх” 95.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын тендерийн баримт бичигт “Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай” гэсэн шалгуурыг хангаагүй байхад “Такамаса” ХХК-ийг шалгаруулж гэрээ байгуулсан.

Шивээговь сумын ОНХС:

“Боловсролын байгууллагын сургалтын хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмжид шинэчлэлт хийх” 50.0 сая төгрөгийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо гэрээ байгуулах эрхийг “Нью престиж констракшн” ХХК-д олгохоор шийдвэр гарсан байтал сумын Засаг даргад “Санаа мед трейд ХХК”-тай гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг хүргүүлж, гэрээ байгуулан санхүүжилтийг олгосон.

Баянтал сумын ОНХС:

“Сургуулийн хоолны ширээ, сандал шинэчлэх” 18.5 сая төгрөгийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо гэрээ байгуулах эрхийг “Их зэст хөгжил ХХК”-д олгосон байтал дүгнэлтийг сумын засаг даргад хүргүүлэхдээ “Хөгжих лүн тал ХХК”-г шалгарсан гэж хүргүүлэн гэрээ байгуулж санхүүжилтийг олгосон.

Үнэлгээний хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг бөглөөгүй, тендер хянан үзэх хүснэгт, тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсэг зурж баталгаажуулаагүй, гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг хүргүүлдэггүй зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Баримтын бүрдэл дутуу ажлын жагсаалт

Хүснэгт № 09

№	Аймаг, сум ОНХС	Ажлын нэр	Гэрээний дүн /сая/	Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл	Тендер хянан үзэх хүснэгт	Тендерийн нээлтийн тэмдэглэл	Гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг сумын Засаг даргад хүргүүлээгүй
1	Аймгийн ОНХС	Гамшгаас хамгаалах /шаардлагатай тоног төхөөрөмж/	22.5	1	1	1	
2	Шивээговь сумын ОНХС	Хогны машин худалдан авах	127.8	1			
3	Баянтал сумын ОНХС	Баяр наадмын талбай шинээр барих	75.2	1			1
4	Баянтал сумын ОНХС	16 дугаар зөрлөгт шинээр хогийн цэг ухаж байгуулах	15.0	1			
5	Баянтал сумын ОНХС	Сургуулийн хоолны ширээ, сандал шинэчлэх	18.5	4			
6	Баянтал сумын ОНХС	Сумын төвийн гэрэлтүүлэг	7.9	4			
Нийт			266.9	12	1	1	1

(Эх сурвалж: Худалдан авах ажиллагааны баримт, аудитын ажлын баримт)

ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг хууль тогтоомж, батлагдсан заавар журмын хүрээнд бэлтгээгүй байна.

Баянтал сумын ОНХС:

1. “154-р байрны 4, 5-р орцны урд талд 24х15 хэмжээтэй авто машины зогсоол хийх” ажилд ТББ-т техникийн тодорхойлолтыг боловсруулж хавсаргаагүй, зөвхөн ажлын даалгаврыг хавсаргасан.
2. Цэцэрлэгийн бүлэгт тоглоом нэмж авах” ажлын техникийн тодорхойлолтод ажлын тоо хэмжээг тусгаагүй.
3. Техникийн тодорхойлолтод тусгасан байвал зохих ажлыг гүйцэтгэхэд тавигдах ерөнхий шаардлага, Монгол улсын стандарт, норм дүрмийг тусгаагүй.

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.18¹⁷, 5.1.19¹⁸, 11 дүгээр зүйлийн 11.1.2¹⁹, 12 дугаар зүйлийн 12.3²⁰, 19 дүгээр зүйлийн 19.2²¹, 29 дүгээр зүйлийн 29.1²², 47 дугаар зүйлийн 47.2.1²³ гэж заасныг зөрчсөн байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, журмыг мөрдөж ажилладаггүй, хариуцсан мэргэжилтэн болон үнэлгээний хорооны гишүүдийн мэдлэг, чадвар дутмаг, хариуцсан ажилдаа хайнга ханддаг, үнэлгээний хорооны дарга болон гишүүдэд хариуцлага тооцдоггүй зэрэг нь зөрчил гарах шалтгаан болж байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.1.2. ОНХС-гийн зарцуулалтын 4 хувь буюу 172.8 сая төгрөгийг бодит гүйцэтгэлд үндэслэн зарцуулаагүй байна.

ОНХС-гийн орлогын гүйцэтгэл 6,610.7 сая төгрөг бөгөөд үүнээс 5,295.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 91 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд 3,789.3 сая төгрөгийг гүйцэтгэгчид, 4.3 сая төгрөгийг гэрээний алдангид, 19.9 сая төгрөгийг захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагад олгож, 429.6 сая төгрөгийг барьцаа дансанд шилжүүлэн 4,243.1 сая төгрөгийн зарцуулалт, 2,367.6 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна.

Аймгийн ОНХС:

170.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү/

Баянтал сумын ОНХС:

244.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ажилд олгосон 123.0 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллагаас санхүүжилт хүссэн албан бичиг, ажлын гүйцэтгэлийн баримт бичиг болон тендерийн баримт бичигт заасан урьдчилгаа төлбөрийн нөхцөл, ажлын бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү/

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1²⁴, 14 дүгээр зүйлийн 14.2.3²⁵, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх

¹⁷ 5.1.18.“Гэрээ байгуулах эрх олгох” гэж хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой худалдан авах гэрээ байгуулах тухай захиалагчийн шийдвэрийг түүнд мэдэгдэхийг

¹⁸ 5.1.19.“техникийн тодорхойлолт” гэж захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний техникийн үзүүлэлт, үйлдвэрлэл, үйл ажиллагааны арга, технологи, түүнд тавих технологийн шаардлагыг тодорхойлсон бүрдүүлбэрийг;

¹⁹ 11.1.2.үндэсний стандарт, техникийн шаардлага, норм, норматив, дүрэм, зааварт үндэслэх, үндэсний стандарт, техникийн норм байхгүй тохиолдолд Монгол Улсын хүлээн зөвшөөрсөн олон улсын стандартад үндэслэх;

²⁰ 12.3.Энэ хуулийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн тогтоосон чадварын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй тендерээс татгалзаж, энэ тухай тендер ирүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

²¹ 19.2.Тендерийн баримт бичигт тендер оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендер оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана.

²² 29.1.Захиалагч тендер нэсэнээс хойш ажлын 15 өдрийн дотор энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендер оролцогч бүрт шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ.

²³ 47.2.1.техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх

²⁴ 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

²⁵ 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2²⁶, 4.2.4²⁷, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2.9²⁸, 4.3.5, 4.3.6, 4.3.7-д заасныг тус тус зөрчсөн байна.

Цаашид төсвийн удирдлагыг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу үр нөлөөтэй хэрэгжүүлэх, урьдчилгаа төлбөрийг зөвхөн тендерийн баримт бичиг болон гэрээний тусгай нөхцөлд заасан /30 хувиас хэтрэхгүй/ нөхцөлөөс хэтрүүлэхгүй байх, санхүүжилтийг ажлын бодит гүйцэтгэлийг баталгаажуулсны дараа олгох албан шаардлагыг төсөв захирагч нарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.2. Иргэдийн амьдралын орчин нөхцөлийг сайжруулах, орон нутгийн хөгжилд бодит нэмэр болохуйц хөрөнгө оруулалт, арга хэмжээ 72 хувийг эзэлж байна.

2.2.1. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 107 төсөл, арга хэмжээнээс 40 төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй, зорилтот түвшин, үр дүндээ хүрээгүй байна.

2023 онд баталсан 107 төсөл, арга хэмжээнээс 91 төсөл, арга хэмжээний гэрээг байгуулсан ба үүнээс 67 төсөл арга хэмжээ нь төлөвлөсөн хугацаандаа хэрэгжсэн 24 төсөл, арга хэмжээ дутуу, 16 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй нь ОНХС-гийн үр дүнд сөргөөр нөлөөлсөн байна. /Дэлгэрэнгүйг аудитын судалгаа №3-аас үзнэ үү/.

Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №10

(Тоо, хувь)

№	Аймаг, нийслэл, сум, дүүрэг	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний тоо	Бүрэн хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний тоо	Төлөвлөгөөний хэрэгжилт
1	Говьсүмбэр Сүмбэр сум	28	21	75.0%
2	Говьсүмбэр Шивээговь сум	16	7	43.8%
3	Говьсүмбэр Баянтал сум	26	16	61.5%
	Сумын дүн	70	44	62.9%
1	Говьсүмбэр аймаг ОНХС	37	23	62.2%
	Нийт дүн	107	67	62.6%

(Эх сурвалж: Аймаг, сумын ИТХ-ын тогтоол, аудитын судалгаа-3)

Аймаг, сумдын ОНХС-гийн төлөвлөгөө 62.6 хувьтай хэрэгжсэн бөгөөд Сүмбэр сум 75.0 хувь, Шивээговь 43.8 хувь, Баянтал сум 61.5 хувь, аймаг 62.2 хувийн хэрэгжилттэй байна.

Үүнд: 1,518.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т заасныг баримтлан 05 дугаар сарын 31-ний дотор зохион байгуулаагүй, зарим шууд гэрээ байгуулах ажлын гэрээг 11, 12 саруудад хийсэн, 1,463.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон шалтгаан нөхцөлийг судалж тогтоогүй нь голлох нөлөөг үзүүлжээ. /Дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү/

²⁶ 4.2.3.Захиалагчийн барилга байгууламжийн ажлын санхүүжилт хүссэн баримт бичгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх олгосны дагуу төсвийн шууд захирагч эсхүл санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн даргын гарын үсгээр хянан баталгаажуулах бөгөөд албан бичиг болон цахим системээр дамжуулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ

²⁷ 4.2.4.Захиалагч барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон барилга угсралтын ажлын календарьчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг мөнгөн дүнгээр илэрхийлж, энэ журмын холбогдох хавсралтад заасан маягтын дагуу гаргана.

²⁸ 4.2.2.9.төсөл, арга хэмжээний санхүүжилт хүссэн гүйцэтгэлийн баримт бичиг, иж бүрдэл, түүний үнэн зөв эсэхэд бүрэн хариуцаж ажиллах

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3²⁹, 15 дугаар зүйлийн 15.4.1³⁰, 41 дүгээр зүйлийн 41.2.7³¹-д заасныг зөрчсөн тул ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг сайжруулах, зөвлөмжийг аймаг, сумын Засаг дарга нарт өгөхөөр шийдвэрлэв.

Тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний чанар, үр дүнг шалгахад дараах зөрчил илэрлээ.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сан:

№	Төсөл, арга хэмжээний нэр	Аудитаар илэрсэн зөрчил-Албан шаардлага өгөх
1	Сүмбэр сумын 1-р баг тээвэрчдийн өргөн чөлөөний гудамж талбайн гэрэлтүүлэг	Гэрэлтүүлгийн зарим шонгууд хазайж, хөдөлгөөн орсон.
2	Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлгийн засвар шинэчлэлтийн ажил	Ажлын тоо хэмжээнд заасан хуучин 27 гэрлийн шон, цахилгааны утсыг буулгах, хэлмэгдэгсдийн хөшөөнөөс Чойр өртөө хүртэл авто зам дагуу 150вт 34 ширхэг лед толгой солих ажил хийгдээгүй. Гэрэлтүүлгийн шонгууд хазайж, зарим хэсэгт хөдөлгөөн орсон.
3	Модны тарьц суулгац, үр үрсэлгээ худалдан авах	Сухайны мөчир 1600ш хүлээн авсан боловч хүлээн авахад нахиа задарсан тул ургаагүй. 5кг хайлаасны үрийг хүлээлгэн өгөөгүй.
4	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн агуулахын зураг төсөв боловсруулах ажил	Гэрээний хугацаа дууссан, сунгалт хийгдээгүй.

Сүмбэр сумын орон нутгийн хөгжлийн сан:

№	Төсөл, арга хэмжээний нэр	Аудитаар илэрсэн зөрчил-Албан шаардлага өгөх
1	Гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмж суурилуулах ажил	Гашууны эгнээний төмөр бетонон тулгуурын оройд суурилуулсан зарим гэрэлтүүлгийн толгойнууд суларч эргэсэн.
2	Тагтын эгнээнд худаг гаргах ажил	MNS 5775:2014 Хот, суурин ундны ус түгээх цэгийн үйлчилгээ Монгол Улсын стандартын 8.4, 8.9 дэх заалттай нийцээгүй.

Шивээговь сумын орон нутгийн хөгжлийн сан:

№	Төсөл, арга хэмжээний нэр	Аудитаар илэрсэн зөрчил-Албан шаардлага өгөх
1	Нийтийн эзэмшлийн байр болон гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай байгуулах, шинэчлэх	Техникийн тодорхойлолтод заасан тоо хэмжээнээс 1 сандал дутуу хийсэн.
2	Боловсролын байгууллагын сургалтын хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмжид шинэчлэлт хийх	Техникийн тодорхойлолтод ширээний хэмжээг 120*40 байхаар боловсруулсан. Энэ нь MNS 6582:2016 Сурагчийн ширээ ба сандал Монгол Улсын стандартын 6.1.2-т 120*45, 50 гэсэн заалттай нийцээгүй. Хуванцар тавцантай сандлуудын гарал үүсэл, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй эсэх тодорхойгүй.

Баянтал сумын орон нутгийн хөгжлийн сан:

№	Төсөл, арга хэмжээний нэр	Аудитаар илэрсэн зөрчил-Албан шаардлага өгөх
1	16 дугаар зөрлөгт шинээр хогийн цэг ухаж байгуулах	Ажлын даалгаварт хогийн цэгийг 4м байхаар тусгасан боловч 3м орчим ухсан. Торон хашааны чанар муу, ажлын даалгавар, тоо хэмжээний дагуу бүрэн гүйцэтгээгүй.
2	154-р байрны 4,5-р орцны урд талд 24х15 хэмжээтэй авто машины зогсоол хийх	ТББ-т техникийн тодорхойлолтыг боловсруулж хавсаргаагүй, зөвхөн ажлын даалгаврыг хавсаргасан. 154-р байрны хойд талын зогсоолыг тоо хэмжээний дагуу гүйцэтгээгүй байхад хүлээн авсан.
3	Цэцэрлэгийн бүлэгт тоглоом нэмж авах	Техникийн тодорхойлолтод ажлын тоо хэмжээг тусгаагүй.

²⁹ 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

³⁰ 15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх

³¹ 41.2.7.хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.


- 4 Нийтийн эзэмшлийн тоглоомын 5.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гэрээг тодорхой талбай эд хөрөнгийг засварлах шалтгаангүйгээр 2023.07.06-2024.03.30 хүртэл сунгасан.

Дээрх зөрчлүүд нь төсөв захирагч нар Төсвийн тухай хуульд заасан төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхгүй байгааг харуулж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3³², 15 дугаар зүйлийн 15.4.1³³ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн /2005/ 5.1.19³⁴, 11 дүгээр зүйлийн 11.1.2³⁵, 19 дүгээр зүйлийн 19.2³⁶, 47 дугаар зүйлийн 47.2.1³⁷, Иргэний хуулийн 350³⁸, 351³⁹, 352, Монгол Улсын үндэсний стандарт MNS 5775:2014, MNS 6582:2016-т заасныг тус тус зөрчсөн тул зөрчлийг, арилгах давтан гаргахгүй байх албан шаардлагыг аймаг, сумдын Засаг дарга нарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.2.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 72 хувийг иргэдийн амьдралын орчин нөхцөлийг сайжруулах, орон нутгийн хөгжилд бодит нэмэр болохуйц хөрөнгө оруулалт, арга хэмжээнд зарцуулсан байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар 6,759.3 сая төгрөгийн 107 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг баталсан.



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг салбараар нь ангилж үзэхэд дэд бүтэц, байгаль орчин, орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх /барилга байгууламжийн засвар, тоног төхөөрөмж, баяр наадам, хөтөлбөр, арга хэмжээ/-ний зардал ихэнх хувийг эзэлж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний 72 хувийг иргэдийн амьдралын орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн гудамж талбайн гэрэлтүүлэг, уурын зуух, төвлөрсөн шугамд холбогдсон

³² 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

³³ 15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх

³⁴ 5.1.19.“техникийн тодорхойлолт” гэж захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний техникийн үзүүлэлт, үйлдвэрлэл, үйл ажиллагааны арга, технологи, түүнд тавих технологийн шаардлагыг тодорхойлсон бүрдүүлбэрийг;

³⁵ 11.1.2.үндэсний стандарт, техникийн шаардлага, норм, норматив, дүрэм, зааварт үндэслэх, үндэсний стандарт, техникийн норм байхгүй тохиолдолд Монгол Улсын хүлээн зөвшөөрсөн олон улсын стандартад үндэслэх;

³⁶ 19.2.Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана.

³⁷ 47.2.1.техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх;

³⁸ 350 дугаар зүйл. Ажил гүйцэтгэгчийн үүрэг

350.1.Ажил гүйцэтгэгч нь дараахь үүрэг хүлээнэ:

350.1.1.гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх;

350.1.6.захиалагчийн өмчлөлд ямар нэгэн доголдолгүй үр дүн шилжүүлэх;

³⁹ 351 дүгээр зүйл. Захиалагчийн үүрэг

351.1.Захиалагч дараахь үүрэг хүлээнэ:

351.1.4.ажил гүйцэтгэгчийн тавьсан шаардлагын дагуу чанар муутай буюу шаардлага хангахгүй материалыг сольж өгөх, буруу зааварчилгаагаа өөрчлөх, ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөх бусад нөхцөл байдлыг арилгах талаар өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээ авах.

худаг, инженерийн шугам сүлжээний шинэчлэл, гудамж талбайн тохижилт, хог хаягдлын асуудлыг шийдвэрлэхэд зарцуулахаар төлөвлөж хэрэгжүүлсэн нь сайшаалтай байна.

Аймгийн ОНХС:

Шивээговь сумын ОНХС-гийн хөрөнгө болон Илчлэг шивээ ОНӨААТҮГ бие даан шийдвэрлэх санхүүгийн боломжгүй уурын зуухны их засварын ажлыг 385.4 сая төгрөгийн хөрөнгөөр хийсэн бөгөөд КВР 2.0 маркын 3 ширхэг уурын зуухыг суурилуулснаар Шивээговь сум найдвартай дулааны эх үүсвэртэй болсон.

Баянтал сумын ОНХС-гийн хөрөнгө болон Талын илч ОНӨААТҮГ бие даан шийдвэрлэх санхүүгийн боломжгүй тул “Баянтал сумын 154-р байрны техникийн давхрын төв инженерийн шугам сүлжээг засварлах, шинэчлэх” ажлыг 93.1 сая төгрөгөөр хийсэн нь сумын төвийн оршин суугчид дулаан, цэвэр усаар найдвартай хангагдах боломжтой болсон.

Наран хэсгийн айл өрхийг цахилгаанаар хангах ажлыг 549.5 сая төгрөгийн хөрөнгөөр хийсэн бөгөөд шинэ суурьшлын бүсийн айл өрхүүд цахилгаанаар хангагдах боломжтой болсон.

Сүмбэр сум ОНХС:

Бурхант, Өлзийт хэсгийн айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлыг 368.1 сая, Тагтын эгнээнд инженерийн шугам сүлжээнд холбогдсон худаг хийх ажлыг 139.0 сая, аймгийн усан сан, өргөх станцын автоматжуулалтын ажлыг 78.5 сая төгрөгөөр хийсэн нь иргэдийн амьдралд эергээр нөлөөлсөн. Мөн Тагт, Гашуун, 4-р багт нийт 130 гэрэлтүүлэг хийсэн бөгөөд төсөв хэмнэх зорилгоор цахилгаан дамжуулах бетон шонг ашигласан нь зардлыг бууруулсан.

Баянтал сум ОНХС

Сумын төвийн гэрэлтүүлэг, камержуулалтын ажлыг 27.9 сая төгрөгөөр хийсэн ба иргэдийн аюулгүй орчинд амьдрах хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн.

Шивээговь сум ОНХС

Илчлэг шивээ ОНӨААТҮГ бие даан шийдвэрлэх санхүүгийн боломжгүй нүүрс тээврийн автомашиныг 237.8 сая, хог тээврийн автомашин 127.8 сая төгрөгөөр авсан бөгөөд сумын төвийн хог хаягдлын менежментийг сайжруулахад эерэг нөлөө үзүүлсэн.


Цаашид удирдлагын шинж чанартай зардал болох төрийн байгууллагын засвар, тоног төхөөрөмжийн зардлыг тухайн байгууллагын төсөвт тусгаж баталснаар ОНХС-гийн хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, иргэд олон нийтийн хүртэж буй үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой байна.

2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон нийт хөрөнгийн 5.5 хувийг зориулалтын дагуу огт ашиглаагүй, 3 хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна.

2.3.1 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон нийт хөрөнгийн 5.5 хувийг огт ашиглаагүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон нийт 2,397.7 сая төгрөгийн 53 төсөл арга хэмжээг ашиглагч байгууллага хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Аудитын талбарын ажлаар ашиглагч байгууллага хөрөнгийг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж буй эсэхийг тулган баталгаажуулахад нийт 180.2 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн "Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд усалгааны худаг гаргах, хашаа барих" 108.6 сая төгрөгийн ажил зориулалтын дагуу огт ашиглаагүй байна. /худаг/
- Сүмбэр сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн Иргэний танхимд төрийн үйлчилгээг сайжруулах шаардлагатай тоног төхөөрөмж" төсөл арга хэмжээнээс 37.5 сая төгрөгийн 20 хөрөнгийг Сүмбэр сумын ЗДТГ-ын бүртгэлд тусгаж зориулалт бусаар дотоод хэрэгцээнд ашигласан, нийт 1.5 сая төгрөгийн 4 хөрөнгийг суурилуулаагүй, зориулалтын дагуу ашиглаагүй байна. /Сүмбэр сумын ЗДТГ – дотор камер 2ш, Сүмбэр сумын 2 дугаар сургууль - шилэн самбар 2 ш/



- Шивээговь сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн "Төрийн албан хаагчдыг орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээ"-ний 17.3 сая төгрөгийн 15 хөрөнгийг зориулалт бусаар удирдлагын албан хэрэгцээнд ашигласан," Тэр бум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих арга хэмжээ"-ний 14.7 сая төгрөгийн 2 хөрөнгийг зориулалтын дагуу огт ашиглаагүй байна. /ус нөөцлөх сав 2ш, усалгааны систем/
- Баянтал сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн "Сумын төвийг камержуулах арга хэмжээ"-ний 0.7 сая төгрөгийн 1 хөрөнгийг одоо хүртэл хүлээлгэж өгөөгүй байна. /32 инч дэлгэц 1ш/



Сумдын ЗДТГ-ын төсөвт удирдлагын болон байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглагдах /компьютер техник хэрэгсэл, тавилга эд хогшил г.м/ төсвийг баталдаггүй, хөрөнгө оруулалтын ажлын суурь дэд бүтцийн /худаг, шугам хоолой/ асуудлыг шийдээгүй байж төсөл арга хэмжээг төлөвлөж санхүүжүүлдэг, хөрөнгө хүлээлцэх комисс хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг шалгаж үзэлгүй ашиглагч байгууллагад хүлээлгэж өгдөг зэрэг хүчин зүйлүүд зөрчил үүсэхэд нөлөөлсөн байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.12⁴⁰, 11 дүгээр зүйлийн 11.1⁴¹, 11.2⁴² дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд холбогдох байгууллагуудад хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хэрэгжүүлсний дараах ашиглалтыг сайжруулж, зориулалтын дагуу ашиглах, ашиглалтын шаардлага хангасан хөрөнгийг ашиглагч байгууллагад бүрэн хүлээлгэж өгөх, ашиглагч байгууллага зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглах, ашиглаж буй эсэхэд хяналт тавих албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.3.2 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон 13.4 сая төгрөгийн 3 хөрөнгө эвдэрч, ашиглалтгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.12-д *“ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна”* гэж заасан байна.

Аудитын талбарын ажлаар ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг тулган баталгаажуулахад нийт 13.4 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Сүмбэр сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн нийт 12,9 сая төгрөгийн 2 хөрөнгө ашиглалтгүй, хадгалалт хамгаалалт зохисгүй байна. /Сүмбэр сумын ИТХ - ухаалаг дэлгэц 1ш, Сүмбэр сумын 2 дугаар сургууль - шүүгчийн онооны самбар 1ш/
- Баянтал сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн нийт 0.5 сая төгрөгийн 1 хөрөнгө ашиглалтгүй, эвдэрсэн /Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг – дээжийн хөргөгч 1ш/



Дээрх зөрчлүүд нь ашиглагч байгууллага хөрөнгөө ариг гамтай эдлээгүй, хадгалалт хамгаалалт зохисгүй байх зэргээс шалтгаалсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1⁴³, 67.2⁴⁴, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.12 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

⁴⁰ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна

⁴¹ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна

⁴² ОНХС-ийн төсөв боловсруулах, батлах, зарцуулах, тайлагнах, бүртгэх, хяналт тавих, зохион байгуулахад хууль тогтоомж зөрчсөн бол тухайн байгууллага, албан тушаалтанд Төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ

⁴³ Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.

⁴⁴ Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна.

Эвдэрч ажиллахгүй болсон хөрөнгийг ашиглалтад оруулах, хадгалалт хамгаалалтыг сайжруулах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

БҮЛЭГ 3

ОНХС-гийн үйл ажиллагаанд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, Удирдлага мэдээллийн системээр дамжуулан иргэд олон нийтэд ил тод тайлагнаагүй байна.

3.1 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээний зөвхөн гүйцэтгэлийн үе шатанд хяналт хэрэгжсэн байна.

3.1.1. Аймгийн ИТХ нь ОНХС-гийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүнд хяналт хэрэгжүүлээгүй, Шивээговь, Баянтал сум захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3⁴⁵, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4⁴⁶-т заасны дагуу аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас ОНХС-гийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх эрх зүйн зохицуулалттай байна. Тус байгууллагаас сумдын ОНХС-гийн зарцуулалтад хийсэн шалгалтаар дараах зөрчлүүд илэрчээ.

Шивээговь сумын ОНХС:

СХДАА-аас 2022 он, 2023 оны эхний 8 сарын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 986.2 сая төгрөгийн 10 зөрчил илрүүлж 1.1 сая төгрөгийн шатахууны зардлыг төлүүлэх 1 төлбөрийн акт, 26.7 сая төгрөгийн 4 албан шаардлага, 592.7 сая төгрөгийн 4 зөвлөмж, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх 365.6 сая төгрөгийн 2 зөрчил илрүүлсэн байна. Тус байгууллагаас хог тээврийн болон нүүрс тээврийн автомашины техникийн тодорхойлолтод заасан даац тоо хэмжээнд хүрээгүй тул авлигатай тэмцэх газарт шалгуулахаар шийдвэрлэжээ.

Баянтал сумын ОНХС:

СХДАА-аас 2022 он, 2023 оны эхний 8 сарын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 707.8 сая төгрөгийн 11 зөрчил илрүүлж 1.0 сая төгрөгийн 1 албан шаардлага, 706.8 сая төгрөгийн 10 зөвлөмж өгсөн байна.

Сүмбэр сумын ОНХС:

СХДАА-аас 2022 он, 2023 оны эхний 7 сарын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 2,747.9 сая төгрөгийн 13 зөрчил илрүүлж 5.3 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 2,742.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 11 зөвлөмж өгсөн байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө төсөл, арга хэмжээний зарцуулалтад санхүүгийн хяналт шалгалтыг хийж үр дүнг тооцсон байна. Цаашид хяналтыг санхүүгийн жилдээ багтаан хийж илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулснаар дотоод хяналтын үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой байна.

Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.1⁴⁷, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.2⁴⁸ 9.4⁴⁹-т заасны дагуу аймаг, сумын ИТХ нь ОНХС-гийн үйл ажиллагааны бүх үе шатанд хяналт тавих зохицуулалттай байна.

⁴⁵ 69.3.Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна.

⁴⁶ 9.4.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

⁴⁷ 64.1.1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

⁴⁸ 3.2.2.Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

⁴⁹ 9.4.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн

Аймгийн ОНХС:

Аймгийн ИТХ-аас 2023 оны ОНХС-гийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Сүмбэр сумын ОНХС:

Сүмбэр сумын ИТХ-н 2022.03.17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор 6 гишүүнтэй хурлын зөвлөлийг байгуулсан байна. Сумын ИТХ-ын 2023 оны 05 сарын 01-ний өдрийн 34 тоот албан бичгээр сумын Засаг даргад, 2023 оны 05 сарын 02-ны 35 тоот албан бичгээр Санхүүгийн албаны даргад ОНХС-гийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой ажлын тоо хэмжээ, зориулалт, байршлыг дур мэдэн өөрчилсөн тохиолдолд гүйлгээ хийхгүй байх, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөх, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын төсөвт өртгийг хэт жижиглэхээс зайлсхийх зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Мөн 2023 оны жилийн эцэст ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн 12 хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлсэн гэх боловч ямар зөрчил илрүүлсэн, хэрхэн шийдвэрлэсэн нь тодорхойгүй байгаа нь хийсэн ажлын эцсийн үр дүнг бууруулж хяналт шалгалт үр дүнгүй болох эрсдэлтэй байна.

Баянтал сумын ОНХС:

Баянтал сумын ИТХ-ын 2021.01.21-ний өдрийн 12 дугаар тогтоолоор 7 гишүүнтэй хяналтын хороог байгуулж ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөтөлбөр, арга хэмжээний үр дүнд хяналт тавих чиг үүргийг хариуцуулсан байна. 2023.02.06, 2023.08.14-ний өдөр хуралдаж ОНХС-гийн ажлын гүйцэтгэлийг сайжруулах зөвлөмж өгсөн байна. Хяналт хэрэгжүүлсэн талаарх 19 мэдээллийг Говьсүмбэр аймгийн Баянтал сум олон нийтийн цахим сүлжээнд байршуулсан байна.

Сумын ИТХ-ын 2023.01.26-ний өдрийн 10, 2023.10.17-ны өдрийн 59 тоот албан бичгээр ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн “Сургуулийн спорт заалыг ариун цэврийн өрөөтэй болгох”, “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх мод бутны суулгац авах”, “621 дүгээр хэсэгт био 00 хийх” ажлын зөрчлийг арилгах албан бичгийг хүргүүлсэн байна. Сумын Засаг даргаас дээрх хяналтаар илэрсэн зөрчлийг хэрхэн шийдвэрлэсэн нь тодорхойгүй байгаа нь хяналт шалгалт үр дүнгүй болох эрсдэлтэй байна.

Шивээговь сумын ОНХС:

Шивээговь сумын ИТХ-ын 2023.02.28-ны өдрийн 05 дугаар тогтоолоор Шивээговь сумын 2023 оны ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл, арга хэмжээнд хяналт тавих хяналтын бүлгийг 3 гишүүнтэй томилсон байна. Хийх ажлын төлөвлөгөөг гаргаж ИТХ-ын даргаар батлуулсан байна.

“Боловсролын байгууллагын сургалтын хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмжид шинэчлэлт хийх”, “Төрийн албан хаагчдын орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээ”, “Нийтийн эзэмшлийн байр болон гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай байгуулах, шинэчлэх”, “Хогны машин худалдан авах”, “Илчлэг Шивээ ОНӨААТҮГ нүүрс тээврийн авто машин худалдан авах” ажлуудад хяналт хэрэгжүүлжээ.

ИТХ-ын хяналтыг ОНХС-гийн төлөвлөлтийн үе шатанд хэрэгжүүлээгүйгээс чиг үүрэгт хамааралгүй, урьдчилсан тооцоо судалгаагүй, зураг төсөвгүй ажлууд батлагдах шалтгаан болж байна. ОНХС-гийн хяналтыг төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, тайлагналын үе шатанд хэрэгжүүлж хяналтын үр ашгийг дээшлүүлснээр ОНХС-гаас хүртэх үр өгөөж нэмэгдэх боломжтой тул зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.1.2 Баянтал, Шивээговь сумын ОНХС-гаар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

тухай хууль, Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм" болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.19⁵⁰, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.12⁵¹-т заасны дагуу барилгын ажлын гүйцэтгэлд захиалагч буюу түүнтэй гэрээний үндсэн дээр аймгийн ГХБХБГ хяналт тавих чиг үүрэгтэй байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр бүрэн болон дутуу хэрэгжсэн 66 төсөл, арга хэмжээнээс дээрх хууль журмын дагуу захиалагчийн хяналт хэрэгжүүлэх шаардлагатай 28 хөрөнгө оруулалтын ажил байна.

Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ХО-ын ажлын судалгаа

Хүснэгт №11

ОНХС-н нэр	Захиалагчийн хяналт хэрэгжүүлбэл зохих ХО-ын тоо	Хяналт хэрэгжүүлсэн ХО-ын ажлын тоо	Хяналт хэрэгжүүлээгүй ажлын тоо
Аймаг	9	7	2
Сүмбэр ОНХС	8	7	1
Шивээговь ОНХС	2	-	2
Баянтал ОНХС	9	-	9
Нийт	28	14	14

(Эх сурвалж: ГХБХБГ-ын захиалагчийн хяналтын тайлан)

Хүснэгтээс харахад: Аймаг, Сүмбэр сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн бол Шивээговь, Баянтал сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлуудад захиалагчийн хяналт хэрэгжээгүй байна.

Эдгээр нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.19⁵², Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.3.1⁵³-т заасныг зөрчсөн байна.

Хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхгүй байгаа нь чанаргүй барилга байгууламж баригдах эрсдэлийг үүсгэж байгаа тул Баянтал, Шивээговь сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа ажилд захиалагчийн хяналт тавих албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3.1.3 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

2022 онд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын нэгдсэн удирдамжаар ОНХС-гийн 2021 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 1,215.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 575.6 сая зөрчилд 7 албан шаардлага, 639.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 13 зөвлөмж өгсөн бөгөөд 2022 оны ОНХС-гийн баримтад үндэслэн хэрэгжилтийг тооцоход албан шаардлага зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

Өмнөх аудитын шийдвэрийг тухайн цаг хугацаанд бүрэн хэрэгжүүлж ажилласан боловч аудитаар өмнөх зөрчлийг давтан гаргасан нь тухайн шалгагдагч байгууллагын удирдлага, мэргэжилтнүүд өөрчлөгдсөнтэй холбоотой байна.

⁵⁰ 37.1.19.барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, фото зургаар баримтжуулан, ил, далд ажлын актыг баталгаажуулах;

⁵¹ “Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно.”

⁵² 37.1.19.барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, фото зургаар баримтжуулан, ил, далд ажлын актыг баталгаажуулах;

⁵³ 5.3.1.Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ;

3.2. ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний мэдээллийг Шилэн дансны цахим хуудас болон Удирдлага мэдээллийн системд ил тод тайлагнаагүй байна.

3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг иж бүрэн тайлагнаагүй, тайланд дүн шинжилгээ хийгээгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.9⁵⁴-д зааснаар аймгийн ХОХБТХ нь 2023 оны сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын тайланг 2024.03.01-ний өдрийн 07/231 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна. Тус журамд заасны дагуу аймгийн ХОХБТХ тайланг хүргүүлэхдээ сумуудаас ирсэн хэрэгжилтийн тайланг нэгтгээгүй, дүн шинжилгээ хийгээгүй, мэдээллийг бүрэн тусгасан эсэхэд хяналт тавиагүй байна. Тухайлбал, доорх мэдээллийг тайланд тусгаагүй байна.

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн сайн туршлага, жишээ, оновчтой санал
2. Энэ журмын 9.4, 9.5-д дурдсан байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, дүгнэлт, акт болон албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга

Аймгийн ХОХБТХ-т нь чиг үүргийн хүрээнд сумдын ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт тавих, сумдаас ирсэн тайланг нэгтгэж, дүн шинжилгээ хийх, мэдээллийг бүрэн хавсаргах, ОНХС-ийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр бодлогын түвшинд санал санаачилга гаргаж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг аймгийн ИТХ-ын тогтоол, сумдын Засаг даргын захирамжаар холбогдох байгууллагуудын хөрөнгөд бүртгүүлсэн байна. Нийт 2,392.7 сая төгрөгийн 54 төсөл арга хэмжээг ашиглагч байгууллага хөрөнгөд, 724.0 сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээг урсгал зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Бүртгэлд тусгаагүй 1,126.4 сая төгрөгийн 22 төсөл арга хэмжээний шалтгаан нөхцөлийг тодруулахад,

- Нийт 1,055.3 сая төгрөгийн 15 төсөл арга хэмжээ он дамжсан /Шалтгаан: улирлаас шалтгаалан ажил хойшилсон, гэрээний хугацаа дуусаагүй, барилга хөгжлийн төвд хянан баталгаажуулалтын ажил удааширсан/
- Нийт 16.1 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг СТА-ын явцад авлагаар тусгуулж, 30.9 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг бүртгэлд тусгах талаар албан шаардлага, зөвлөмж хүргүүлсэн
- Нийт 24.1 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг бүртгэлд тусгуулах албан бичиг 2023 оны эцэст хүргүүлсэн

СТА-аар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

3.2.3 УМС-д сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн 58.8%-ийг огт мэдээлээгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлд УМС-д сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнг мэдээлэхээр заасан байна. Горим, сорилын хүрээнд УМС-д оруулсан мэдээллийг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Аймгийн хэмжээнд УМС-д 8,600.4 сая төгрөгийн батлагдсан төсөв, нийт гэрээний дүн, зарцуулалтыг тус тус оруулаагүй, иргэдэд ил тод мэдээлээгүй

⁵⁴ Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг тусгана.

Хүснэгт №12 УМС-д мэдээлээгүй зөрчлийг задалж харуулбал:

Аймаг, сумдын нэр	Батлагдсан төсөв	Ил тод болгосон	Мэдээлээгүй	Нийт гэрээний дүн	Ил тод болгосон	Мэдээлээгүй	Зарцуулалт	Ил тод болгосон	Мэдээлээгүй
Аймаг	3,098.5	2,021.4	1,077.1	2,182.2	-	2,182.2	2,175.4	-	2,175.4
Сүмбэр	1,833.2	1,235.3	597.9	1,197.4	413.0	784.4	1,041.5	386.5	654.9
Шивээговь	1,309.7	1,151.6	158.1	932.5	365.6	566.9	683.6	347.3	336.3
Баянтал	517.9	450.5	67.4	468.9	425.2	43.7	344.9	388.8	(43.9)
Нийт дүн	6,759.3	4,858.7	1,900.5	4,781.0	1,203.8	3,577.2	4,245.4	1,122.6	3,122.7

Эх сурвалж: УМС-д хийсэн аудиторын тулгалт

Мэдээлээгүй шалтгаан нөхцөлийг тодруулбал: УМС-д батлагдсан төсөв, хуваарилалт, санхүүжилт нь Сангийн яамнаас и-хуулгаас зөрүүтэй татагддаг, уг зөрүүтэй мэдээлэл нь гараас засагддаггүй, УМС-д мэдээлэл оруулах мэргэжилтнийг тодорхой болгоогүй, албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй, хариуцсан мэргэжилтэн, албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллаагүй, жилд 1-2 удаа солигдсон зэрэг нөхцөл байдлаас шалтгаалсан байна.

Энэхүү УМС-ийг бүрэн ашиглах нь хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих боломжтой болох, цаашид системээр дамжуулан мэдээллийн сан бүрдүүлэх, хуваарилалт төлөвлөлт хийх, ОНХС-ийн санхүүжилт, гүйцэтгэлийг удирдах, тайлагнах, үнэлэх зэрэг олон боломж бий болох ач холбогдолтой юм. Иймд УМС-ийн хөгжүүлэлтийг сайжруулах саналыг хүргүүлэх, ач холбогдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

ОНХС-ийн УМС-д зөрүүтэй татагдаж байгаа, тус системийн хөгжүүлэлтийг сайжруулах тухай Сангийн яаманд санал хүргүүлэх уламжлах саналаар тайланд оруулах, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүнг үнэн зөв, иж бүрэн оруулах, иргэдэд ил тод мэдээлэх талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.2.4 ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүх сумд хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1⁵⁵, 6.3.9⁵⁶-д заасны дагуу мэдээлсэн эсэхийг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрсэн.

- Аймгийн ОНХС нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тухайн жилийн төсөв 864.9 сая, гэрээний дүнг 96.9 сая, санхүүжилтийг 166.4 сая төгрөгөөр тус тус дутуу мэдээлсэн, төлөвлөгөө, гүйцэтгэлийг 1,2,3,5,6,9 саруудад хугацаа хоцроож мэдээлсэн
- Сүмбэр сумын ОНХС нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд гэрээний дүнг 43.1 сая төгрөгөөр дутуу мэдээлсэн, ОНХС-ийн төлөвлөгөөг огт мэдээлээгүй
- Шивээговь сумын ОНХС нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд гэрээний дүнг 162.0 сая төгрөгөөр илүү мэдээлсэн, төлөвлөгөө, гүйцэтгэлийг 1,2,3,5,6,9 саруудад хугацаа хоцроож мэдээлсэн
- Баянтал сумын ОНХС нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд гэрээний дүнг 52.2 сая төгрөгөөр дутуу, зарцуулалтыг 43.9 сая илүү мэдээлсэн, төлөвлөгөө, гүйцэтгэлийг 1,2,3,5,6,9 саруудад хугацаа хоцроож мэдээлсэн

Дээрх зөрчил нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хэрхэн мэдээлэх талаар ойлголтын зөрүүтэй байдал, хариуцсан мэргэжилтэн, албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллаагүй, жилд 1-2 удаа солигдсон гэх мэт шалтгаанаас үүссэн байна.

Иймд дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, иж бүрэн байршуулах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

⁵⁵ тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор

⁵⁶ орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл

Гүйцэтгэлийн аудитаар нийт 346.4 сая төгрөгийн 15 зөрчил илрүүлж, 346.4 сая төгрөгийн 7 зөрчилд албан шаардлага, сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 7 зөвлөмж өгч, Архангай аймаг дахь Төрийн аудитын газар уламжлах 2 саналыг хүргүүлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, сумдад хуваарилсан байна.
2. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй 90 хувь уялдсан байна.
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ ний 21 хувь нь иргэдийн саналд үндэслээгүй байна.
4. Сумдын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, сургалтад хамруулах, тэдгээрт мэргэжил арга зүйн туслалцааг үзүүлэх шаардлага тулгарсан байна. /Худалдан авах ажиллагааны газар, Санхүү, Төрийн сангийн хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс/
5. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний 72.0 хувь нь орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр болохуйц үр нөлөөтэй байна.
6. 2023 онд гэрээ байгуулсан 82 төсөл, арга хэмжээнээс 52 буюу 63.4 хувьд нь шууд гэрээ байгуулсан байгаа нь төсөвт өртгийг хэт жижиглэн үр ашиггүй төсөл, арга хэмжээнд зарцуулагдах эрсдэл байгааг харуулж байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

1. Аймгийн ОНХС-н хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд хяналт хэрэгжүүлж, түүний үр дүнг ил тод нээлттэй тайлагнах

Аймгийн Засаг даргад:

1. Аймгийн ИТХ-аар батлагдсан орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт 62.2 хувьтай байгаа тул дутуу болон огт хэрэгжээгүй ажлын гүйцэтгэлийг хангуулж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх

Сумдын Засаг дарга нарт

1. Сумдын ИТХ-аар батлагдсан орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт Сүмбэр 75.0 хувь, Шивээговь сум 43.8 хувь, Баянтал 61.5 хувьтай байгаа тул дутуу болон огт хэрэгжээгүй ажлын гүйцэтгэлийг хангуулж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх
2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг аймаг, сумын хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусгах, сумын ИТХ-аар батлуулах

3. Төсөвт өртгийг хэт жижиглэн үр ашиггүй олон жижиг төсөл, арга хэмжээнээс зайлсхийж тоо бус чанарт анхаарах
4. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, иж бүрэн байршуулах

Аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст

1. ОНХС-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу сумдаас ирүүлсэн ОНХС-ийн төлөвлөлт, хэрэгжилтийн тайланг нэгтгэж, дүн шинжилгээ хийх, аймгийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр бодлогын түвшинд санал санаачилга гаргаж ажиллах
2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг аймаг, сумын хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусгах, аймгийн ИТХ-аар батлуулах
3. Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд гаргасан худгийг орон нутгийн ногоон байгууламжийн усалгаанд ашиглаж төсвийн хөрөнгийн үр ашгийг сайжруулах, цаашид ашиглалтгүй хөрөнгө бэлтгэхгүй байх
4. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, иж бүрэн байршуулах

Дээрх зөвлөмжийг 2025 оны 06 дугаар сарын 10-ны дотор биелүүлж, хэрэгжилтийг ирүүлнэ үү.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлуулах саналтай байна. Үүнд:

1. ОНХС-ийн Удирдлага мэдээллийн системийн хөгжүүлэлтийг сайжруулах, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлангийн системүүдтэй холбож уялдаа холбоог сайжруулах
2. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д арга хэмжээний төлөвлөлтийг тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу хөрөнгө оруулалтын ажлаас тусад нь төлөвлөх нарийвчилсан журам шаардлагатай байгаа тул журамд зохицуулалтын асуудлыг тусгах

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас/Факс: (976) 7054 3118,
И-мэйл: zdtg.gsa@gmail.com, Вэбсайт: www.govisumber.gov.mn

2024.07.04 № 07/743
танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.САРАНТУЯА ТАНАА

Ахлах аудитор
Б. Дарлалбаатар
Самалтай танилцсан
Тийлэмж хүргэв
2024.07.04

Хариу хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 204 дугаар албан бичигтэй танилцаж доорх саналыг хүргүүлэв.

Асуудлын бүртгэлийн 8 дахь заалтад заагдсан “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд усалгааны худаг гаргах, хашаа барих 108.6 сая төгрөгийн ажил зориулалтын дагуу огт ашиглаагүй, хадгалагдаж байна” гэсэн албан шаардлагыг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

Тус арга хэмээ нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 03 дугаар зөвлөмжийн 2.1 дэх заалтын дагуу бэлтгэх хангах зорилгоор төлөвлөсөн бөгөөд мөн Эрдэнэт үйлдвэрээс манай аймагт 5.0 сая мод тарихаар хүсэлт гаргасны дагуу 30 га талбайг төлөвлөн ОНХС-ийн хөрөнгөөр тус газарт худаг гаргасан.

Уг Эрдэнэт үйлдвэрээс хэрэгжүүлэх мод тарих ажил гүйцэтгэгч шалгараагүйн улмаас 2023 онд ажил хийгдээгүй энэ онд хийгдэхээр хүлээгдэж байна.

Мөн гаргасан худгийн дэргэд усны нөөц сав байршуулах шаардлагатай тул 2024 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийхээр тендер сонгон шалгаруулалтыг зарлаад байна.

Тус хөрөнгө оруулалтаар худалдан авсан хашааны 50 хувийг Хаялага нуурын дэргэд мод тарьж хашаалсан. Цаашид мод тарих газруудыг хашаалахаар төлөвлөсөн.

Иймээс уг асуудлыг зөрчлийн бүртгэлийн албан шаардлагыг зөвлөмж болгуулах хүсэлтэй байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлт,
хөрөнгө оруулалтын хэлтсийн
ДАРГА Г.ХОНГОР



ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГА

2 дугаар баг, Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42017
Утас: 7054 3249, Цахим шуудан: info@sumber.gs.gov.mn,
Цахим хуудас: www.sumber.gs.gov.mn

2024.07.04 № 428

танай -ны № -т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.САРАНТУЯА ТАНАА

Сумын 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн
бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө хөгжлийн сангийн
тайлангийн төсөлд саналгүй болно.

ДАРГА



Т.БАТ-ЭРДЭНЭ

Ахлах аудитор
Б.Хархандатаг
Саналтайг тамиууц
тайланг хүлээн
2024.07.04

/word/toot/a5.doc

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА

Лун, Баянтал сум, Говьсүмбэр аймаг, 42040
Утас: 9411 3190, Цахим хуудас: www.bayantal.gs.gov.mn

2024.07.04 № 216

танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл, асуудлын бүртгэлтэй танилцсан бөгөөд санал, тайлбаргүй байна.

ЗАСАГ ДАРГА



Б.ГАНБАЯР

Мөөг аугаах
Б. Дарханбаатар
Саналтай танилцсан
Тайланг бүтээх
2024/07/04

26240204


ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ


ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА
42030 Говьсүмбэр аймаг, Шивээговь сум,
Утас: 7054 6426, И-мэйл: shiveegovi.zdtg@gmail.com
2024.07.04 № 2/351
тантай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.САРАНТУЯА ТАНАА

Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн
сангийн 2023 оны гүйцэтгэлийн аудитын санхүүгийн
тайлан, зөрчлийн бүртгэлтэй танилцаж, тайлбарыг
хүргүүлэв.


Хавсралт 3 хуудастай.

ОРЛОГЧ ДАРГА  Л.БАДАМХАНД



Ахлах аудитор
Б.Доржсүхбаатар
Саналтай танилцуулсан
тайланг хүргэв

C:\Documents\B-H\TOOT.doc


2024.07.04

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Аймгийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн тайлбартай танилцаад тайлангийн төсөлд тусгасан албан шаардлагыг Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд гаргасан худгийг орон нутгийн ногоон байгууламжийн усалгаанд ашиглаж төсвийн хөрөнгийн үр ашгийг сайжруулах зөвлөмж болгон өөрчлөлт оруулав.

Шивээговь сумын Засаг даргаас ирүүлсэн тайлбартай танилцаад хууль эрх зүйн үндэслэлтэй тайлбар болон түүнийг дэмжсэн нотлох баримтыг ирүүлээгүй тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэж Тэргүүлэх аудиторын тушаалаар тайланг баталгаажуулав.

№	ОНХС	Хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Гүйцэтгэлээр олгосон нийт санхүүжилт	Үүнээс: гүйцэтгэлд олгоогүй санхүүжилтийн хэмжээ	Бодит үндэслэн	Тайлбар
1	АОНХС	Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлгийн засвар шинэчлэлтийн ажил	150.0	150.0	148.7	29.7		
2	АОНХС	Онцгой байдлын газрын сургалт мэдээллийн төвийн зураг төсөв боловсруулах ажил	20.0	20.0	20.0	20.0	100% олгосон	урьдчилгаа
3	БТОНХС	Баяр наадмын талбайг шинээр барих	80.0	75.3	37.6	37.6	50% олгосон	урьдчилгаа
4	БТОНХС	16 дугаар зөрлөгт шинээр хогийн цэг ухаж байгуулах	15.0	15.0	10.5	10.5	70% олгосон	урьдчилгаа
5	БТОНХС	Баяр наадмын стадион талбайг өргөтгөх нэмэлт ажил хийх	115.8	95.6	47.8	47.8	50% олгосон	урьдчилгаа
6	БТОНХС	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх мод бутны суулгац авах	16.5	16.0	11.2	11.2	70% олгосон	урьдчилгаа
7	БТОНХС	Нийтийн эзэмшлийн тоглоомын талбай эд хөрөнгийг засварлах	5.5	5.5	3.9	3.9	70% олгосон	урьдчилгаа
8	БТОНХС	6/04 кв дэд станц, цахилгааны шугамын зураг төсөв	8.1	20.0	8.1	8.1	41% олгосон	урьдчилгаа олгож төсөвт өртгөөс давсан гэрээ байгуулсан.
9	БТОНХС	Усан сангийн /250мкуб багтаамжтай/ өргөх станц магадлалын зураг төсөв	4.0	4.0	4.0	4.0	100% олгосон	урьдчилгаа
Нийт			414.9	401.3	291.8	172.8		

№	ОНХС	Хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Ажил гүйцэтгэх хугацаа	Гүйцэтгэгч
1	АОНХС	Нарангийн гэр хороололд цахилгаан татах ажил	549.5	2023.11.03 2023.12.23 2024.04.30	Кон-арч ХХК
2	АОНХС	Аймгийн төвлөрсөн хогийн цэгт цахилгаан татах ажпын зураг төсөв боловсруулах ажил	5.0	2023.12.21 2024.03.01	Ингүүмэл эрчим ХХК
3	АОНХС	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн агуулахын зураг төсөв боловсруулах ажил	10.0	2023.06.07 2023.06.27	Ориентплюс ХХК
Дүн			564.5		
4	Сүмбэр ОНХС	Төрийн албан хаагчдад зориулсан нийтийн байрны засвар	116.8	2023.11.15- 2023.12.30	Их хайрханы хишиг
5	Сүмбэр ОНХС	Өлзийт суурьшлын бүсийн цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх, сайжруулах	230.0	2023.11.30-	Содон эрчис ХХК
Дүн			346.8		
6	ШГОНХС	1-р багт хийгдэх нийтийн биеийн тамирын талбай байгуулах ажил	354.6	2023.09.13 2023.11.30	Цагаан толгойн нуур ХХК
Дүн			354.6	0	0
7	БТОНХС	Баяр наадмын талбайг шинээр барих	80.0	2023.10.30- 2023.11.30- 2024.05.01	Дүүрэн зул ХХК
8	БТОНХС	16 дугаар зөрлөгт шинээр хогийн цэг ухаж байгуулах	15.0	2023.08.01- 2023.09.01- 2024.04.01	Гедро тех инженеринг ХХК-Агро гарден сервис
9	БТОНХС	Баяр наадмын стадион талбайг өргөтгөх нэмэлт ажил хийх	115.8	2023.09.08- 2023.11.15-2024- 05-01	Дүүрэн зул ХХК
10	БТОНХС	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх мод бутны суулгац авах	16.5	2023.07.31- 2024.07.31	Гедро тех инженеринг ХХК Агро гарден сервис
11	БТОНХС	нийтийн эзэмшлийн тоглоомын талбай эд хөрөнгийг засварлах	5.5	2023.06.06- 2023.07.06- 2024.03.30	Хөгжих лүн тал ХХК

12	БТОНХС	Соёл урлаг, спорт заалны зураг төсөв	8.0	2023.12.14- 2024.04.15	Жаргалант хийц ХХК
13	БТОНХС	6/04 кв дэд станц, цахилгааны шугамын зураг төсөв	8.1	2023.12.12- 2024.03.12	Ялгуун баян ХХК
14	БТОНХС	Усан сангийн /250мкуб багтаамжтай/ өргөх станц магадлангийн зураг төсөв	4.0	2023.12.12- 2024.01.15 2024.02.26	Кингсий инженер энд констракшн консалтинг групп ХХК
Дүн			252.9		
Нийт			1,518.9		

Хавсралт №3

Огт хэрэгжээгүй ТАХ-ний жагсаалт

/сая төгрөг//

№	ОНХС	Хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
1	АОНХС	Аймгийн төвд явган хүний замыг нэмэгдүүлэх ажил	70.00
2	АОНХС	Сүмбэр суманд нийтийн эзэмшийн талбай, тохижилтийн ажилууд хийх	232.27
3	АОНХС	Аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгт утаагүй хог шатаах зуух худалдан авах	500.00
4	АОНХС	Шивээговь сумын ариутгах татуургын шугамын ажпын төсвийг шинэчлүүлэх ажил	1.50
5	АОНХС	Төсвийн байгууллагуудын засварын ажпын зураг төсөв боловсруулах ажил	10.00
Дүн			813.77
6	Сүмбэр ОНХС	Шинэ суурьшлын бүсэд цахилгаан татах	107.10
7	Сүмбэр ОНХС	Хүүхдийн тоглоомын талбайн тохижилтыг сайжруулах	190.00
8	Сүмбэр ОНХС	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн усалгааны систем суурилуулах ажил	100.00
9	Сүмбэр ОНХС	Сүмбэр сумын 1, 2-р багийн цэвэр усны шугам угаах ажил	20.00
Дүн			417.10
10	ШГОНХС	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх сэргээн засварлах	52.91
11	ШГОНХС	Шинэ сууришлын бүсэд худаг гаргах	47.00
12	ШГОНХС	Хүүхэд залуучуудын ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих арга хэмжээ	44.00
13	ШГОНХС	2024 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын их засварын ажлын зураг төсөв	20.00

14	ШГОНХС	2024 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх ажлын зураг, төсөв	20.00
Дүн			183.91
15	БТОНХС	Малчдын бүлэг бэлчээр хаших	19.00
16	БТОНХС	Худаг шинээр гаргах ажил	30.00
Дүн			49.0
Нийт			1,463.8

Хавсралт №4

Төсөл, хөтөлбөрийн арга хэмжээнээс чиг үүрэгт хамааралгүй зарцуулалт

/мянган төгрөг/

№	Хөтөлбөр /Зориулалт бус зарцуулалт	Шатахуун	Томилолт	Хоол цай	Шагнал, дэмжлэг	Буудал	Үндэсний наадмаас бусад, баяр	Бусад /нийтийн эрх ашигт нийцээгүй арга хэмжээ	Нийт дүн
1	Соёл урлагийг дэмжих арга хэмжээ	0.6		2.0	12.4		16.5	4.6	36.0
2	Боловсролын дэмжих арга хэмжээ			1.7	1.0			2.2	4.9
3	Аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ							2.0	2.0
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг хангах	0.2	0.9		1.7			0.5	3.3
5	Хоршоо ахуйн үйлчилгээ хөгжүүлэх арга хэмжээ	2.8				0.1		17.1	20.0
6	Гэр бүл, хүүхэд залуучуудыг дэмжих арга хэмжээ							3.0	3.0
7	Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ	0.4		0.7	1.7			2.3	5.2
8	хөтөлбөр арга хэмжээ тодорхойгүй	2.1							2.1
Нийт дүн		6.2	0.9	4.4	16.8	0.1	16.5	31.7	76.5

Хавсралт №5

Төсвийн тухай хуулийн шалгуур, шаардлагыг хангаагүй ТАХ-ний судалгаа

/сая төгрөг/

№	Сум	Хөрөнгө оруулалт	Гүйцэтгэл	нийцээгүй шалгуур, шаардлага
1	Сүмбэр сум	Хог хаягдал зөөвөрлөх автомашин худалдан	98.3	Төсвийн тухай хуулийн 29.2.6, урьдчилсан судалгаа
2	Сүмбэр сум	Тагтны эгнээнд худаг гаргах ажил	137.8	Төсвийн тухай хуулийн 29.2.2, зураг бхгүй
3	Сүмбэр сум	Гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмж суурилуулах ажил	79.3	Төсвийн тухай хуулийн 29.2.2, зураг бхгүй
4	Сүмбэр сум	Усан сан, өргөх станцын эх үүсвэрийн автоматжуулалт	78.8	Төсвийн тухай хуулийн 29.2.6
5	Сүмбэр сум	Авто замын босоо тэмдэг, тэмдэглэгээг нэмэгдүүлэх	10.0	Төсвийн тухай хуулийн 29.2.6
6	Сүмбэр сум	6-р цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах	21.4	Төсвийн тухай хуулийн 29.2.6
7	АОНХС	Сүмбэр сумын 1-р баг тээвэрчдийн өргөн чөлөөний гудамж талбайн гэрэлтүүлэг	118.6	Төсвийн тухай хуулийн 29.2.6
8	АОНХС	Нарангийн гэр хороололд цахилгаан татах ажил	535.2	Төсвийн тухай хуулийн 29.2.6
9	АОНХС	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд усалгааны худаг гаргах, хашаа барих ажил	108.6	Төсвийн тухай хуулийн 29.2.6
10	АОНХС	Агаарын чанарын мэдээлэл авах цэгийн цахилгаан хангамжийн ажил	11.5	Төсвийн тухай хуулийн 29.2.6
11	АОНХС	Баянтал суманд шинээр баригдсан “Ус түгээх худагт” ухаалаг тоног төхөөрөмж суурилуулах ажил	12.0	Төсвийн тухай хуулийн 29.2.6
12	АОНХС	Сүмбэр сумын 1-р баг Тээвэрчдийн өргөн чөлөөнөөс 2 дугаар сургуулийн уулзвар хүртэлх авто замын ажил	22.0	Төсвийн тухай хуулийн 29.2.6
13	АОНХС	Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлгийн засвар шинэчлэлтийн ажил	148.7	Төсвийн тухай хуулийн 29.2.6
14	АОНХС	Гамшгаас хамгаалах газар хөдлөлтийн чичирхийллийг хэмжих багаж суурилуулах худалдан авах	19.4	Төсвийн тухай хуулийн 29.2.6
15	АОНХС	Гамшгаас хамгаалах аврах ажиллагааны хийлдэг завь худалдан авах	10.0	Төсвийн тухай хуулийн 29.2.6
16	АОНХС	Модны тарьц суулгац, үр үрсэлгээ худалдан авах	37.0	Төсвийн тухай хуулийн 29.2.6

17	АОНХС	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хүрээнд өрхийн тариалан эрхлэлтийг дэмжих зорилгоор хүлэмж худалдан авах	132.5	Төсвийн тухай хуулийн 29.2.6
Нийт дүн			1,581.0	